

Булган аймгийн ХААНМСҮТ-д санхүүгийн хяналт шалгалт  
хийсэн дүнгийн тухай

**НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО**

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 05 сарын 16-ны өдрийн 1/13 дугаар удирдамжийн дагуу Булган аймаг дахь Хөдөө аж ахуйн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2015, 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай, Боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА**

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч О.Гантуяа, Ж.Оюун нар 2017 оны 08 сарын 07-ны өдрөөс ажлын 20 хоногт багтаан шалгалтыг хийв.

Хяналт шалгалт хийх удирдамжид заагдсан хугацаанд шалгалтыг эхлүүлээгүй шалтгаан нь Хутаг-Өндөр сумын төсөвт албан байгууллагууд, аймгийн Автотээврийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх зайлшгүй шаардлагатай болсон учир хойшлогдсон.

**ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД**

ХАА-н МСҮТөвийн 2015-2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ  
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

Булган сумын 4-р багт байрлах Хөдөө аж ахуйн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн, нийгмийн түншлэлд тулгуурласан насан туршийн чанартай сургалт явуулах үндсэн зорилготой.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/126 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар захиргаа хүний нөөцийн алба 23, сургалтын алба 19 нийт 42 орон тоо батлагдаж, захирал, захиргаа хүний нөөцийн менежер, арга зүйч, сургалтын албаны менежер, дотоод хяналт шинжилгээний мэргэжилтэн, эрх зүй гадаад харилцаа хариуцсан ажилтан, статистик мэдээлэл хариуцсан ажилтан, нийгмийн түншлэл хариуцсан ажилтан, багш 8, дотуур байрны багш 3, нийгмийн ажилтан, номын санч, нягтлан бодогч, нярав, жолооч, слесарь, үйлчлэгч 2, тогооч 2, жижүүр 2, галч 4 нийт 35 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна. Хөдөлмөрийн сайдын 2016 оны 02 сарын 04-ний өдрийн А/30 дугаар тушаалын хавсралтаар ХАА-н МСҮТөвийн бүтэц, орон тоог нийт 42 ажиллагсадтайгаар буюу Захирал, Сургалтын алба хариуцсан менежер, Менежер, Хүний нөөц гадаад харилцаа хариуцсан ажилтан, Хяналт шинжилгээ, мониторинг хариуцсан ажилтан, Нийгмийн түншлэл хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, статистик хариуцсан ажилтан, Цахим тоног төхөөрөмж, мэдээллийн сан, сүлжээ хариуцсан ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан ажилтан, сургуулийн эмч, номын санч, нягтлан бодогч, нярав, Захирлын туслах, бичиг хэрэг, архив хариуцсан ажилтан, тогооч, тогоочийн туслах ажилтан, жолооч, Слесарь цахилгааны ажилтан тус бүр 1, багш 14, дотуур байрны багш 3, галч 4, сахиул 2, үйлчлэгч 2 байхаар батлагдсанаас 36 орон тоотой ажилласан байна.

Тус төвийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2015 оны 01 сарын 01-ээс 2015 оны 10 сарын 20-ны өдрийг хүртэл С.Оюунбат, 2015 оны 10 сарын 21-ээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал Н.Пүрэвсайхан, 2-р гарын үсгийг 2015 оны 01 сарын 01-нээс 2015 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэл Ч.Гантулга, 2016 оны 01 сарын 20-нээс 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал О.Хонгорзул нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040037021 тоот, нэмэлт санхүүжилтийн 040037402 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

#### ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Тус төв нь “Си Эс Ай”, “Гэрэлт хөхийн тэнцвэр аудит” байгууллагаар 2015 оны 12 сарын 31-ний өдрөөрх, 2016 оны 12 сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар,

журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна гэж зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

ХАА-н МСҮТөвийн 2014-2015 оны цалин хөдөлмөрийн хөлсөнд МХГ-аас шалгалт хийж 11 заалттай 1 албан шаардлага, 4 актаар нийт 12446.8 мянган төгрөгийн төлбөр тогтоож төсөвт төвлөрүүлэхээр тогтоосон байна. Үүнээс МХГ-ын Хөдөлмөрийн байцаагчийн 2015 оны 09 сарын 29-ний өдрийн 06-06-015/28 тоот актаар цагийн багшаар ажиллаж байсан О.Золзаяа, Э.Пагма нарт амралтын олговор 681.1 мянган төгрөгийн олгохоор тогтоосныг олгосон, тус 2 багшийг батлагдсан бүтэц орон тоонд байхгүй орон тоо шинээр үүсгэн хөдөлмөрийн хөлсний доод түвшин 192.0 мянган төгрөгөөр тус бүр цалинжуулж 2 сар ажиллуулсан нийт 768.0 мянган төгрөгийн төлбөр тогтоож захирал С.Оюунбат төлүүлж төсвийн орлогод төвлөрүүлэхээр, Хөдөлмөрийн байцаагчийн 2015 оны 09 сарын 29-ний өдрийн 06-06-015/26 тоот актаар 2015 оны 05 сарын 21-ны өдрийн 29 тоот тушаалаар дотуур байрны багш Ч.Амарсайханд үндсэн цалингийн 60%-иар 298.0 мянган төгрөг, туслах тогооч Б.Мөнхзаяад үндсэн цалингийн 60%-иар 238.0 мянган төгрөгийн нийт 536.0 мянган төгрөгийн урамшууллыг хууль эрх зүйн үндэслэлгүй олгосонд төлбөрийн акт тогтоож захирал С.Оюунбат, нягтлан бодогч Ч.Гантулга нараар хувь тэнцүүлэн төлүүлж төсвийн орлогод төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн ч одоог хүртэл тус актуудын төлбөрийг барагдуулаагүй байна.

2016 оны 10 сард Булган аймгийн Аудитын газраас “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-ийн 2015 он, 2016 оны эхний 9 сарын байдлаарх санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитаар 14500.0 мянган төгрөгийн өртөгтэй e-tvet сургалт удирдлагын нэгдсэн системийг орлогод тусгаагүй байсныг тусгуулахаар хугацаатай албан шаардлага өгснийг программ хангамжийн дансанд орлогод авч, оюутны тэтгэлгийн илүү олгосон 280.0 мянган төгрөгийн төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

#### ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

ХАА-н МСҮТөвийн 2015-2016 оны касс харилцах, цалингийн баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын баримт, аудитын байгууллагаар баталгаажуулаагүй 2016 оны санхүүгийн тайлан, дотуур байрны суралцагчдын ирцийн бүртгэл, 2015, 2016 оны хагас, бүтэн жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын баримт, хяналт шинжилгээ мониторинг хариуцсан ажилтны хийсэн ажлууд, ГОУХА-нийгэмлэгийн төсөл, Хөдөлмөрийн яамны хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгө, материалын архивлаж үдэгдээгүй баримтууд, хөдөлмөрийн дотоод журам, өөрийн үйл ажиллагааны орлогын баримт (задгайгаар) зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал С.Оюунбат, сургалтын албаны менежер Н.Пүрэвсайхан, нягтлан бодогч Э.Нямдорж, нягтлан бодогчоор ажиллаж байсан Ч.Гантулга, нярав П.Эрдэнээул, хяналт шинжилгээ

үнэлгээ мониторинг хариуцсан ажилтан А.Ганцоож нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:2015 онд төсвөөс 461019.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 428230.3 мянган төгрөгийг авч, үндсэн үйл ажиллагааны орлогыг 3000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, 1700.0 мянган төгрөгийг оруулж, нийгмийн даатгалын сангаас тэтгэмжийн 7794.0 мянган төгрөг, ГОУХАНийгэмлэгийн “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь–2” төслөөс 20829.5 мянган төгрөг, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас 22216.8 мянган төгрөг бүгд 480770.6 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна. 2016 онд улсын төсвөөс 405276.5 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж, тодотголоор 5633.1 мянган төгрөгийг хасч, 8000.4 мянган төгрөгийг нэмж, шүүхийн шийдвэрийн дагуу олгох 35217.0 мянган төгрөг нийт 432860.8 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 2494.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас 3358.7 мянган төгрөг, ГОУХАНийгэмлэгийн “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь–2” төслөөс 4129.7 мянган төгрөг, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас 7580.0 мянган төгрөг бүгд 450423.8 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

2015 онд төсөвт зардлыг 464019.3 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 437724.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажилчдын цалинд 245286.5 мянган төгрөг, ндш-д 27358.6 мянган төгрөг, тогтмол зардалд 25350.9 мянган төгрөг, хангамжийн бараа материалд 5733.6 мянган төгрөг, хоол хүнс 15667.5 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэл 743.4 мянган төгрөг, урсгал засвар 5318.0 мянган төгрөг, томилолт 2463.3 мянган төгрөг, төлбөр хураамж бусад татварууд 1319.2 мянган төгрөг, жижиг эд хогшил 973.7 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 17362.5 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 10938.9 мянган төгрөг тус тус зарцуулж, 3 хүнд ХЧТА-ны тэтгэмж 48.7 мянган төгрөг, 3 хүний ЖА-ны тэтгэмж нийт 7745.3 мянган төгрөгийг өгч, үлдэгдэл 71414.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

2016 онд төсөвт зардлыг 435860.8 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 278699.5 мянган төгрөг, тогтмол зардалд 23321.5 мянган төгрөг, нормативт зардалд 17898.1 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 6260.5 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 3807.6 мянган төгрөг, албан томилолтын зардалд 1800.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 2436.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 55664.4 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад таван жил тутамд олгох, тэтгэмжид 43977.8 мянган төгрөг, оюутан төгсөгчдийн 10-12 сарын тэтгэлэгт 3080.0

мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1724.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн 040037402 дугаар, 8394.9 мянган төгрөгийг бүртгэлийн үндсэн 040037021 дугаар данснаас бүгд 10118.9 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт орлого, санхүүжилтийн талаар: Төсвийн тодотголоор нэмэгдсэн орлогоос тээврийн хэрэгслийн татварт 878.8 мянган төгрөг, тайлан баталгаажуулалтын ажлын хөлсөнд 1346.5 мянган төгрөг, зам ашиглалт, агаарын бохирдлын төлбөр хураамжид 211.2 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан багшид таван жил тутамд олгох тэтгэмжид 5564.0 мянган төгрөгийг зарцуулсан, Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 383 дугаар шийдвэрийн дагуу 2016 оны 12 сарын 21-нд иргэнд 35217.0 мянган төгрөг олгосон байна.

2015 онд өөрийн үйл ажиллагааны орлого 3000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр заалны түрээсийн орлогоос 57.0 мянган төгрөг, дадлагын орлогоор 1642.9 мянган төгрөг нийт 1699.9 мянган төгрөгийн орлого орж, төлөвлөгөөг 1300.1 мянган төгрөгөөр тасалсан. 2016 онд өөрийн үйл ажиллагааны орлого 3000.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр шигшиж үлдээсэн нунтаг нүүрсийг Булган Мээж ХХК-д борлуулсанаас 1631.0 мянган төгрөг, заалны түрээсийн орлогоос 146.3 мянган төгрөг, дадлагын орлогоор 574.0 мянган төгрөг, байгууллагын ажилчдад зарсан ногооны орлогоос 123.36 мянган төгрөг, хоолны орлогоос 20.0 мянган төгрөг нийт 2494.7 мянган төгрөгийн орлого орж, төлөвлөгөөг 505.3 мянган төгрөгөөр тасалсан.

Боловсролын тухай хуулийн 43.1.7, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19.3 дахь заалтуудыг үндэслэн 2015 онд захирал, нийгмийн ажилтан нарт нийт 7603.5 мянган төгрөг, 2016 онд сургалтын алба хариуцсан менежер, сургалтын менежер, дотуур байрны багш, багш нар нийт 9 албан хаагчид тус байгууллагад таван жил тогтвор суурьшилтай ажилласны нэг удаагийн тэтгэмжид 43977.7 мянган төгрөгийг олгосон байна.

Нэмэлт санхүүжилтийн 040037402 дугаар дансаар 2015 онд ГОУХАНИйгэмлэгийн төслөөс 10829.5 мянган төгрөг, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас 32216.7 мянган төгрөг нийт 43046.2 мянган төгрөгийн орлого орж, гүйцэтгэлээр 22216.7 мянган төгрөгийг 1-9 сарын 131 оюутны тэтгэлэгт, 10000.0 мянган төгрөгийг E-TVET сургалт удирдлагын нэгдсэн системийн урьдчилгаа төлбөрт, Ойжуулагчийн ангийн оюутны 2 удаагийн дадлагыг Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сум, 1 дадлагыг Булган аймгийн Бугат сумдад хийсэн оюутны хоол хүнсний материалд 3126.9 мянган төгрөг (иргэн Бурмаа, Мядагмаа, Д.Цогтсайхан, Өндөр цэгц, Ангийс дүв ХХК-аас авсан), тээвэр шатахууны зардалд 1642.6 мянган төгрөг, 6060.0 мянган төгрөгийг ойжуулагчийн анги шинээр бэлтгэх сургалтын танилцуулга, нээлттэй хаалганы өдөр, багш нарын

заах арга зүйн сургалтанд тус тус зарцуулсан байна. 2016 онд ГОУХАНИйгэмлэгээс ойн ангийн дадлагын үйл ажиллагааг санхүүжүүлэх зориулалтаар 4129.7 мянган төгрөг, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангаас 7580.0 мянган төгрөг нийт 11709.7 мянган төгрөгийн орлого орж, гүйцэтгэлээр E-TVET” сургалт удирдлагын нэгдсэн системийн үлдэгдэл төлбөрт 4500.0 мянган төгрөг, 15 оюутан төгсөгчдийн тэтгэлэгт 3080.0 мянган төгрөг, ойжуулагчийн ангийн дадлагын шатахуунд 833.6 мянган төгрөг, хоол хүнсний материалд 1572.1 мянган төгрөгийг (иргэн Бурмаа, Өндөр цэгц, Очирхүү дэлгүүрээс авсан) зарцуулж, үлдэгдэл 1724.0 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

*Цалин урамшууллын талаар:* ХАА-н МСҮТөвийн захирлын 2015 оны 02 сарын 02-ны өдрийн 08 дугаар тушаалаар Хангайн бүсийн МБСБ-уудын 6 дугаар спортын наадамд гар бөмбөгийн тэмцээнд тэргүүн байр эзэлсэн 5 ажилтанд тус бүр 80.0 мянган төгрөг нийт 400.0 мянган төгрөгийн урамшуулалыг шагнал урамшууллын зардлаас, 2015 оны 05 сарын 21-ны өдрийн 29 тоот тушаалаар дотуур байрны багш Ч.Амарсайханд үндсэн цалингийн 60%-иар 298.0 мянган төгрөг, туслах тогооч Б.Мөнхзаяад үндсэн цалингийн 60%-иар 238.0 мянган төгрөгийн нийт 536.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшуулалын зардлаас, 2015 оны 06 сарын 10-ны өдрийн 33 тоот тушаалаар нягтлан бодогч Ч.Гантулгад 1 сарын үндсэн цалин 560.8 мянган төгрөгийг цалингийн сангаас, 2015 оны 12 сарын 14-ний өдрийн 89 тоот тушаалаар оны шилдэг ажилтнаар шалгарсан ажилтануудад 1 сарын үндсэн цалингаар слесарь, мужаан М.Чулуунбатад 404.9 мянган төгрөг, мэргэжлийн багш Ч.Өлзийбаатарт 560.8 мянган төгрөг, заах аргач багш Д.Орхонтуулд 556.4 мянган төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан байна.

ХАА-н МСҮТөвийн захирлын үүргийн түр орлон гүйцэтгэгчийн 2015 оны 11 сарын 24-ны өдрийн 74 дугаар тушаалаар 16 ажилтанд 10-25%-иар 1376.9 мянган төгрөг, 2015 оны 12 сарын 14-ний өдрийн 88 дугаар тушаалаар 18 ажилтанд 10-25%-иар 1266.4 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл цалин олгосон.

2016 онд хоол унааны хөнгөлөлтийг 10 сараас эхлэн нийт 4376.8 мянган төгрөг, ур чадварын нэмэгдлийг 1, 2 дугаар улирал, 7 сараас хойш сар бүр олгосон байна.

**6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:**

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	1582605623	18223635		1600829258
2	Авто тээврийн хэрэгсэл	78445145.87	0		78445145.87
3	Машин тоног төхөөрөмж	183140431.38	36578794		219719225.38
4	Тавилга, эд хогшил	89025180	0		89025180
5	Номын фонд /Түүх соёл,	6353250	644000		6997250

	музейн дурсгалт зүйлс/				
6	Зам, гүүрийн байгууламж	644000			644000
7	Программ хангам	1418500	0		15918500
	Дүн	1940988130.25	55446429		1996434559.25

2015 оны эхэнд 1940988.1 мянган төгрөг хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 644.0 мянган төгрөгийн номыг түүх соёлын дурсгалт зүйлсд худалдан авч, Хөдөлмөрийн аям болон ГОУХАНИйгэмлэгээс 18223.6 мянган төгрөгийн иж бүрэн гэр, 13 нэр төрлийн 21 ширхэг 36578.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогодон нийт 1996434.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	1600829258	0		1600829258
2	Авто тээврийн хэрэгсэл	78445145.87	0		78445145.87
3	Машин тоног төхөөрөмж	219719225.38	57112000		276831225.38
4	Тавилга, эд хогшил	89025180	0		89025180
5	Номын фонд /Түүх соёл, музейн дурсгалт зүйлс/	6353250	0		6353250
6	Зам, гүүрийн байгууламж	644000			644000
7	Программ хангамж /"E-TVET" сургалт удирдлагын нэгдсэн систем/	1418500	14500000		15918500
	Дүн	1996434559.25	71612000		2068046559.25

2016 оны эхэнд 1996434.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан бөгөөд төсвийн хөрөнгөөр 1842.5 мянган төгрөгийн, Хөдөлмөрийн яамны хөрөнгө оруулалтаар 55269.5 мянган төгрөгийн, Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сангийн хөрөнгөөр 14500.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч оны эцэст 2068046.6 мянган төгрөгийн хөрөнгөтэй тайлан гарсан байна.

Хөдөлмөрийн яамны хөрөнгө оруулалтаар 1227.5 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 24 ком суурин компьютер, 1595.1 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 5 ком зөөврийн компьютер, 721.8 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 2 ш өнгөт принтер, 1895.7 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 3 ш хувилагч машин, 3578.5 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 2 ш хувилагч машин-1, 118.1 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 2 ш проекторын цагаан самбар, 517.6 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 1 ш олон үйлдэлтэй принтер, 209.9 мянган төгрөгийн

нэг бүрийн үнэтэй 3 ш энгийн принтер, 720.8 мянган төгрөгийн нэг бүрийн үнэтэй 3 ш проектор нийлүүлэгдсэнийг машин тоног төхөөрөмжийн тайланд бүртгэж, эд хариуцагчид хариуцуулан картжуулсан байна.

**6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:**

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Хүнсний материал	3932062	12393170	15540740	784492
2	Бичиг хэрэг	955255	985350	1147875	792700
3	Аж ахуйн материал	26417056	81210085	10480766	97146435
4	Тусгай зориулалт	18772127	5825950	11266024	13332053
5	Эм боох материал	103900		90400	13500
6	Сэлбэг хэрэгсэл	7878986	1073000		8951986
7	Барилгын засвар	390000	1058900	1118900	330000
8	Түлш шатах тослох	1378300	15268950	15716650	930600
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>59827656</b>	<b>117815405</b>	<b>55361295</b>	<b>122281766</b>

ГОУХАН-ийн төслөөс үйлдвэрлэлийн дадлагын сургалтын орчныг сайжруулах зорилгоор нийт 78113.1 мянган төгрөгийн 181 нэр төрлийн 775 ширхэг ажлын багаж хэрэгсэл, ажлын цамц, гутал гэх мэт материалуудыг хандивласан байна.

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Хүнсний материал	784492	16008430	15881080	911842
2	Бичиг хэрэг	792700	1596700	1565500	823900
3	Аж ахуйн материал	97146435	25153028.34	6038080	116264383.34
4	Тусгай зориулалт	13332053	8184459	6571240	14945272
5	Эм боох материал	13500	194050	50450	157100
6	Сэлбэг хэрэгсэл	8951986	240000	483000	8708986
7	Барилгын засвар	330000		330000	
8	Түлш шатах тослох	930600	14372675.65	14853275.65	450000
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>122281766</b>	<b>65749342</b>	<b>45769625.65</b>	<b>142261483.34</b>

ГОУХАН-ийн төслөөс үйлдвэрлэлийн дадлагын сургалтын орчныг сайжруулах зорилгоор нийт 19544.2 мянган төгрөгийн аяны гудас, хөнжил, гал тогооны хэрэгслүүд, гэр ахуйн тавилга гэх мэт материалуудыг хандивласан байна. 2016 оны эхэнд байсан 930.6 мянган төгрөгийн 20 тонн нүүрсний үлдэгдэл дээр



Уулс заамар, Илчит металл ХХК, иргэнээс 9992.8 мянган төгрөгөөр 221 тонн нүүрс, Хүн чулууны бэл ХХК, иргэн Сайнжаргалаас 640.0 мянган төгрөгөөр 4 машин түлшний мод худалдан авч, оны эцэст 450.0 мянган төгрөгийн 6 тн нүүрс үлдсэн байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2015 оны эхэнд бичиг хэрэг 8.0 мянган төгрөг, томилолт 1083.6 мянган төгрөг, хоол хүнс 3100.3 мянган төгрөг, урсгал засвар 152.3 мянган төгрөг, хүмүүст өгөх өглөг 3082.6 мянган төгрөг, бусад өглөг 456.3 мянган төгрөг нийт 7883.1 мянган төгрөгийн өглөгтэй байсныг барагдуулсан ч, 2016 онд өглөгийн хувьд оны эхэнд таван жил тутамд олгох тэтгэмжийн 5563.9 мянган төгрөг, томилолтын 126.8 мянган төгрөг, урсгал засварын 252.6 мянган төгрөг, шуудан холбооны 322.0 мянган төгрөг нийт 6265.3 мянган төгрөгийн өглөгийг бууруулж оны эцэст өглөггүй тайлан баланс гарсан байна.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд нийт 132 мэдээлэл оруулахаас 2015 онд 17 мэдээллийг хугацаанд нь 115-ыг хугацаа хоцроосон, 2016 онд 121 мэдээллийг хугацаанд нь, 11-ийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Хугацаа хоцроож мэдээлсэн шалтгаан нь нэгдсэн программд өөрчлөлт орсоноос мэдээлсэн мэдээллийг дахин оруулсантай холбоотой.

6.6. Дотоод аудитын талаар: Хөдөлмөрийн сайдын хяналт үнэлгээ шинжилгээ, дотоод аудитын тайлангийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, зөвлөмжийг биелэлийг хангаж ажилласан. Гал тогооны орчин эрүүл ахуйн стандартын хэрэгжилт хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, агуулахын хадгалалт хамгаалалт эмх цэгцэнд, эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод сургуулийн өмч эд хөрөнгийн ашиглалт хамдагалатанд урьдчилан бэлдэж байгаа байдалд, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 2016 оны эхний хагас жилийн мэдээлэл байршуулсан байдалд, E-TVET сургалт удирдлагын нэгдсэн систем, веб сайтын ашиглалтанд тус бүр удирдамж боловсруулан хяналт шинжилгээ, мониторинг хийсэн байна.

6.7. Оюутан суралцагчдын тоо, хувьсах зардлын талаар: Тус төв нь 2014-2015 оны хичээлийн жилийн элсэлтийн хяналтын тоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа, орон нутгийн захиалгад үндэслэн элсэлтийн квотыг 260 оюутан элсүүлэхээр төлөвлөж аймгийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан хэрэгжүүлж ажилласан байна.

№	Хичээлийн жил	Оюутны тоо					
		Төсвийн хуваарьт	Шинээр элссэн	Анги дэвшсэн		Суралцсан	Төгссөн
1	2014-2015 он	260	81	60		141	86
2	2015-2016 он		70	46		116	52
3	2016-2017 он	126	112	25		137	76

2015 онд 8 мэргэжлээр 141 оюутан суралцаж, 86 оюутан төгсөж, 2016 онд 7 мэргэжлээр 116 оюутан суралцаж, 52 оюутан төгссөн байна.

Оюутан суралцагчдын хувьсах зардлын талаар: Дотуур байр 62 оюутны хүчин чадалтай ба дунджаар 2015 онд 27 /6932:253/ оюутан байрлаж хоолны зардалд 15540.7 мянган төгрөгийг, 2016 онд 28 /6945:248/ оюутан байрлаж хоолны зардалд 15881.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2016 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, түүний дагуу дотуур байрны суралцагчдын хоол, хүнсний материал нийлүүлэх тендерийг холбогдох хуулийн дагуу зарлаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, гүйцэтгэгчээр 01 сарын 22-оос “Өндөр цэгц ХХК-ийг, 05 сарын 05-аас Очирхүү ХХК-тай гэрээ байгуулан хүнс материалыг худалдан авсан байна.

#### ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

2016 онд сургуулийн дотуур байрны оюутнуудын амьдрах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор багш, ажилтнууд санаачлага гарган аян өрнүүлж 18 өрөө, үүдний хэсгийн тааз, нэг давхарын хана, өөрсдийн өрөөг, тогооч нар гал тогооны хувцас солих өрөөний хана зэргийг засварлаж тохижуулсан байна.

Шалгагдсан онуудад “Эд хөрөнгө хариуцан ажиллах гэрээ”-г эд хариуцагч бүртэй байгуулан ажилласан байна. Эд хөрөнгийн тооллогын бүртгэлийг зохих маягтын дагуу бүртгэж архивласан

Тушаалаар томилогдсон тооллогын комисс тооллогыг цаг хугацаанд нь хийж, орлогод авагдаагүй 17 нэр төрлийн, эзэнжүүлээгүй 46 нэр төрлийн нийт 63 нэр төрлийн хөрөнгийг илрүүлж, байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна.

Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж, зөрчилгүй тушаасан.

#### НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСЭН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. 2015 онд Ё.Отгонхишигтээс 70.0 мянган төгрөгийн плетка, 400.0 мянган төгрөгийн берзент, Н.Отгоноос 300.0 мянган төгрөгийн 04 трубо, Б.Хосбаяраас 43.5 мянган төгрөгийн аарц, 2016 онд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн төслөөс ирсэн 1338876 төгрөгийн ойн багаж хэрэгсэл, иргэн Т.Батчулуунаас 182.0 мянган төгрөгөөр 140 л сүү, Очирхүү дэлгүүрээс 737.4 мянган төгрөгөөр хүнс, Enjoy хэвлэх үйлдвэрээс 9.5 мянган төгрөгөөр хэвлэмэл хуудас, Минж дэлгүүрээс 65.0 мянган төгрөгөөр бичиг хэрэг нийт 2332.8 мянган төгрөгөөр худалдан авч тайланд орлогодсон боловч орлогын баримтыг санхүүгийн баримтанд үдэж архивлаагүй.

2. Төсвийн хөрөнгөөр олж бэлтгэсэн 2738.2 мянган төгрөгийн хүнс бараа материалыг тухайн материалын дансанд орлого авалгүй шууд зардалд бичсэн нь Сангийн сайдын 2016 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар”-ын 4.21 дэх заалтыг зөрчсөн.
3. Шатахууны тайлан гаргалт, тооцоо бодолтын байдлыг шалгахад 2015 онд “НИК” ШТСтанцид шатахууны үнэнд 040037021 дугаар бүртгэлийн данснаас 4352.9 мянган төгрөг, 040037402 дугаар нэмэлт санхүүжилтийн данснаас 1642.6 мянган төгрөг бүгд 5995.5 мянган төгрөгийг шилжүүлсэнээс нярав 585.8 мянган төгрөгийн /1642600-1056800=585800/ шатахууныг тайланд орлогодоогүй шууд зардалд тусгасан, түлш халаалтын 1512.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн 1666.9 мянган төгрөгийн шатахууныг тайланд тусгасан, 2016 онд “НИК” ШТСтанцид шатахууны үнэнд 040037021 дугаар бүртгэлийн данснаас 4644.6 мянган төгрөг, 040037402 дугаар нэмэлт санхүүжилтийн данснаас 833.6 мянган төгрөг бүгд 5478.2 мянган төгрөгийг шилжүүлсэнээс нярав 1860.2 мянган төгрөгийн /5478156-3617924=1860232/ шатахууныг тайланд орлогодоогүй, нягтлан бодогч няравын тайлангаар гарсан шатахууны орлого дээр 11 сарын 23-нд авсан 462.0 мянган төгрөгийн шатахууныг нэмж шатахууны орлогыг 4079.9 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд тусгаж, тайлант онд нийт **1398.2** мянган төгрөгийн /5478156-4079924=1398232/ шатахууныг орлогодоогүй шууд зардалд тусгасан, захирлын тушаалаар томилогдсон элсэлт зохион байгуулахаар Булган, Архангай, Өвөрхангай аймгийн сумдаар 04 сарын 15-аас 22, 05 сарын 03-аас 12, 09 сарын 05-аас 10 хүртэл явсан шатахууны зардлыг тайланд зарлагадаагүй, шатахуун олгох зөвшөөрлийн хуудсыг санхүүгийн баримтанд үдэж архивлаагүй, жолоочийн шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцолгүй шилжүүлсэн мөнгөн дүнгээр шууд зардалд бичдэг, спидометрийн заалтыг тухай бүр бичиж хэвшээгүй.
4. Тооллогын комисс нь 2016 оны жилийн эцсийн машин тоног төхөөрөмжийн тооллогын бүртгэлд тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4 нэр төрлийн 5 ш 1703.5 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгийг 10 ш 3461.0 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгө байгаагаар, программ хангамжийн тооллогын бүртгэлд 14500.0 мянган төгрөгийн өртөгтэй 1 ш мэдээллийн системийн программыг 2 ш байгаагаар тус тус бүртгэсэн, нярав үндсэн хөрөнгийн тайлан гаргадаггүй, нягтлан санхүүгийн программдаа үндсэн хөрөнгийг шууд шивдэг, Санхүүгийн

тайлангийн үндсэн хөрөнгийн тайлан ТБСТТ-1 маяганд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 644.0 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйл дээр орлогодсон номны үнэнд багтсан 125.0 мянган төгрөгийн номыг давхар барилга байгууламжид орлогодсоноор харуулсан

5. Анхан шатны баримтуудын гарын үсгийн бүрдэлт, хөтлөлт шаардлага хангахгүй байна. Тухайлбал: агуулахын бүртгэлийг дэвтэр маягтаар хөтлөөгүй, нэмэгдсэн хөрөнгийг “Үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх” анхан шатны баримтаар хүлээн авдаггүй, шаардах хуудсыг буруу, засвартай үйлдсэн, захирал, нягтлан бодогчийн зөвшөөрсөн гарын үсэг зурагдаагүй байхад материал зарлагадсан, зарим шаардах хуудаст зөвшөөрсөн, олгосон материалын тоо хэмжээ тавиагүй, 06 сарын 21-нд Хүн чулууны бэл компаниас 66000 төгрөгөөр авсан палк зарлагын баримтгүй, хоолны цэс архивлагдаагүй.
6. 2016 онд Уулс заамар, Илчит металл , Хүн чулууны бэл ХХК, иргэн Сайнжаргал, Гантулга нараас худалдан авсан 4 машин түлшний мод, 221 тонн нүүрсийг хэн хэн байлцаж, хэзээ буулгаж, хүлээлцсэн талаарх үйлдсэн баримт байхгүй, уурын зууханд хэрэглэсэн нүүрсийг авсан хэмжээгээр бөөндүүлж сарын эцэст зарлага болгодог, галч нарт тавьж олгосон нүүрсний анхан шатны баримтыг слесарь цахилгаан хариуцсан ажилтанаар хөтлүүлдэг.
7. 2014 оны жилийн эцсийн тайлангаар томилолтын өглөгийн үлдэгдэл 1083.6 мянган төгрөг байхад 2015 оны томилолтын зардлаас 1177.5 мянган төгрөг өгч 93.9 мянган төгрөг илүү олгосон байна.
8. Уурын зуухны шатсан нүүрсний хог ачиж буулгахаар Г.Ганзориг, Г.Бэлгүүтэй нартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, ажлын хөлсөнд нийт 600.0 мянган төгрөгийг түлш халаалтын зардлаас олгосон ч нийгмийн даатгалын шимтгэл, хаоат-ыг шилжүүлэхдээ цалингийн сангаас шилжүүлсэн, тухайн хүний НД-ын дэвтэрт бичилт хийсэн эсэх тодорхойгүй байна.
9. Нэмэлт санхүүжилтийн 040035402 тоот данснаас 2015 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01 тоот бэлэн мөнгөний хүсэлтээр Төрийн сан дахь ХААН банкны 5270118020 тоот дансанд 1232.8 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас, 2015 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 03 тоот бэлэн мөнгөний хүсэлтээр 986.4 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас, 2015 оны 09 дугаар сарын 04-ны

өдрийн 04 тоот бэлэн мөнгөний хүсэлтээр 585.8 мянган төгрөгийг бензин шатахууны зардлаас, 05 тоот бэлэн мөнгөний хүсэлтээр 1117.6 мянган төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас нийт 3922.6 мянган төгрөгийн бэлэн мөнгөний тайлан гаргаагүй.

10. Хөдөө орон нутгийн Боловсролын байгуулагад тасралтгүй 3-5 жил ажилласан багш нарын тэтгэмжийг олгохдоо ХАА-н МСҮТ-ийн захирал С.Оюунбат нь “Тэтгэмж олгох тухай” 2015 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн 46 тоот тушаалыг гаргахдаа Б.Ганаасүрэн, нийгмийн ажилтан Г.Давхарбаяр нараас гадна өөрийн нэрийг оруулж, өөртөө тушаал гаргаж 4442.0 мянган төгрөгийн тэтгэмжээ авсан байна.
11. 2015 оны үндсэн үйл ажиллагааны орлогын баримт огт байхгүй, 2016 оны нэмэлт санхүүжилтийн дансны баримт, өөрийн үйл ажиллагааны баримтуудыг үдэж архивлагдаагүй задгайгаар шалгуулсан.
12. 11 дүгээр сарын хоолны өдөрлөгийн дүн 2258.9 мянган төгрөг байхад хүнсний материалын тайланг 2264.0 мянган төгрөгөөр гаргаж 5.1 мянган төгрөгийн илүү, 12 дугаар сарын хоолны өдөрлөгийн дүн 2263.6 мянган төгрөг байхад хүнсний материалын тайланг 2265.3 мянган төгрөгөөр гаргаж 1.7 мянган төгрөгийн илүү нийт 6.8 мянган төгрөгийн хүнсний материал илүү, байрны багшийн сурагчдын бүртгэлээс, тогоочийн өдөрлөгийн сурагчдын тоо 6 дугаар сард 2 хүүхэд, 12 дугаар сард 1 хүүхэд нийт 3 хүүхэд илүү бүртгэж 6.7 мянган төгрөгийн хүнсний материал илүү тус тус зарлагдсан.
13. Нярав үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тайлан гаргадаггүй, нягтлан бодогч санхүүгийн программ дээр шивдэг, оны эцэст эд хөрөнгийн тооллого хийж баримтжуулсан. Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тайлан ТБСТТ-1 маяганд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 644.0 мянган төгрөгийн номыг түүх соёлын дурсгалт зүйл дээр орлогодсон байж давхар 125.0 мянган төгрөгийн номыг барилга байгууламж хэсэгт орлогодсоноор харуулсан.
14. Харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдсэн баримт байхгүй байна.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА,  
ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 2 заалттай 1 албан шаардлага,

2951.1 мянган төгрөгийн төлбөрийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 7 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

#### АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7.1, 7.7 дахь, /хуучнаар/ 13.1, 13.7 дахь /шинэчилсэн/, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь, Боловсролын тухай хуулийн 43.1.7, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 19.3 дахь заалтуудын хэрэгжилт хангалтгүй, мөн шалгалтаар илэрч байгаа нийтлэг зөрчлүүд нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих дотоодын хяналт сул байна дүгнэлээ.

#### АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Анхан шатны баримтгүйгээр гүйлгээ хийдэг, зардал гаргадаг явдлыг таслан зогсоож Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах

Сэлбэг шатахууны зардлын гүйцэтгэлд хяналт тавих хяналтыг сайжруулж, шатахууны тооцоог бодож хэвших, автомашины шатахууны 100 км-т зарцуулах нормыг тооцохдоо Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм”, “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар”-ыг мөрдөж ажиллах

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН

БАЙЦААГЧ

О.ГАНТУЯА

Ж.ОЮУН

